



Save the Children
UK *10 жил*

Монголд

10 жил

Хүүхдийг Ивээх Сан (Англи)
2004 он

Захирлын үг

Хайрт хүүхдүүд ,хүндэт эцэг эхчүүд, эрхэм анд найз нараа Та бүхэнд баярын мэнд дэвшүүлье.

Хүүхдийг Ивээх Сан (Англи) Монгол оронд үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойш 10 жил өнгөрөөд байна. Манай байгууллагыг Монголын ард түмэн эхнээсээ л халуун дотно хүлээн авсан бөгөөд хийх зүйл их байсан тул бид ажилдаа шуурхай орсон билээ. Зах зээлийн эдийн засагт шилжиж буй Монгол орны хүүхэд багачуудын сурч боловсрох,амьдрах нөхцөл байдлыг сайжруулахын төлөөх чин хүсэл, эрмэлзлэлд хөтлөгдөн бүхий л нөөц бололцоогоо дайчлан ажиллаж байсан хэдий ч эхний жилүүдэд хандивлагчидын тоо цөөн байсны улмаас хөрөнгө мөнгө төдийлөн их байгаагүй, нөгөө талаар ажилтныхаа мэдлэг боловсролыг дээшлүүлэх шаардлага байнга урган гарч ирдэг байлаа. Гэвч бид хамтдаа дээрх бэрхшээлүүдийг даван туулсаар ирсэн юм.



Энэ дашрамд манай ажил үйлсэд үнэтэй хувь нэмэр оруулж, хамтдаа амжилтанд хүрсэн Монголын болон олон улсын байгууллага, хувь хүмүүст гүн талархал илэрхийлье. Миний бие тэдний нэрийг жагсаан дурьдмаар байвч энэхэн номын хуудаснаа багтахгүй бизээ. Гэхдээ та бүхэн талархал хүлээж, магтаал сонсохын тулд бус, харин Монголын хүүхдүүдэд дэлхийн бусад оронд амьдарч байгаа хүүхдүүдийн нэгэн адил сайхан ирээдүйд хүрэх тэгш боломж олгохын төлөө бидэнтэй хамтран ажилласан билээ. Үйлс нэгт нөхөд маань одоо ч Монголын хүүхдүүдийн тусын тулд хэрэгжүүлэх нэн чухал хөтөлбөрүүдийг бидэнтэй хамтран боловсруулж, дэмжин хэрэгжүүлж байгаа нь манай ажилтнуудад цуцалтгүй хөдөлмөрлөх урам зориг нэмсээр байна.

Бүхий л ажил үйлс маань НҮБ-ын Хүүхдийн Эрхийн Конвенцид тулгуурласан байдаг бөгөөд Конвенцийн заалт бүхэн амжилттай хэрэгжинэ гэдэгт бид итгэдэг юм. Богино хугацаанд Конвенцийн зорилгод хүрэх боломжгүй ч гэсэн бид нааштай өөрчлөлтүүдийг гаргаж байна.

Энэхүү ажил үйлс ундарсан арван жилийн өндөрлөгөөс миний бие, хүн бүхэн, байгууллага бүр Монголын хүүхдийн оюун санаа, авьяас билэг, эрүүл мэндийн төлөө зүрх сэтгэлээ зориулан, ямагт шинийг эрэлхийлж ажлаасай хэмээн хүсч байна. Монгол дахь Английн Хүүхдийг Ивээх Сан та бүхний үр хүүхдийн сайн сайхны төлөө улам ихийг хийх болно.

Карло Пушкарица
ХИС (Англи)-ийн Монгол дахь
Хөтөлбөрийн Захирал

ӨМНӨХ ҮГ

Хүн төрөлхтөний гэрэлт ирээдүй болсон хүүхэд багачуудын төлөө зүрх сэтгэлээ зориулж явдаг бүх хүмүүс, байгууллага хамт олонд Хүүхдийг Ивээх Сангийн (Англи) ажилтнуудын өмнөөс чин сэтгэлийн талархал илэрхийлж мэндчилгээ дэвшүүлье.



Хүүхдийг Ивээх Сан (Англи) нь Дэлхийн нэгдүгээр дайнд нэрвэгдсэн хүүхдүүдэд туслах зорилгоор Эглантайн Жебб гэдэг эмэгтэйн санаачилгаар анх 1919 онд байгуулагджээ. Хүүхдийг Ивээх Сан (ХИС) нь одоо дэлхийн 60 гаруй оронд хүүхдийн сайн сайхны төлөө үйл ажиллагаа явуулдаг төрийн бус, ашгийн төлөө бус олон улсын байгууллага бөгөөд Олон улсын Хүүхдийг Ивээх Сангийн Эвслийн гишүүн юм.

1990 оны эхээр Монгол оронд нийгмийн тогтолцоо өөрчлөгдөж, шилжилтийн үеийн хүндрэл тохиолдсоны улмаас олон үйлдвэр, аж ахуйн байгууллага хаагдаж, ажилгүйчүүдийн тоо нэмэгдэн хүмүүсийн амьдралд сөрөг үр дагаврууд гарч эхэлсэн.

ХИС (Англи) Монгол дахь энэхүү нийгмийн өөрчлөлт нь хүүхдүүдэд хэрхэн тусаж байгаад үнэлэлт өгөх зорилгоор 1993 онд Лондон дахь Зүүн болон Зүүн Өмнөд Азийг хариуцсан хөтөлбөрийн ажилтан Маттею Буллардыг томилон ажиллуулж улмаар 1993 оны 7-р сард Монгол Улсын Засгийн газартай хамтран ажиллах гэрээг байгуулжээ.

Уг гэрээнд хоёр тал Хүүхдийн Ивээх Сангийн үйл ажиллагааг “Монгол дахь хүүхдийн өсөлт хөгжил, сайн сайхны асуудалтай холбогдсон үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэх, ялангуяа эмзэг дорой хүүхдүүд, нийгмийн давхаргын хэрэгцээг урьтал болгон анхаарч, Монголын Засгийн Газарт дэм зүүлэх үүднээс хамтран ажиллана” гэж тодорхойлжээ.

1994 оны 2-р сард ХИС-ийн Монгол дахь анхны суурин төлөөлөгч буюу хөтөлбөрийн зохицуулагчаар ноён Жон Боклер томилогдож, суурин төлөөлөгчийн газраа байгуулан, гурван монгол ажилтантай ажлаа эхэлжээ. Тэрээр нөхцөл байдалд тулгуурлан олон шинэ хөтөлбөр, төслүүдийг боловсруулан хэрэгжүүлэхдээ төрийн болон ТББ-уудтай хамтран ажиллах, бодлогод нөлөөлөх, өөрийн болон түншлэгч байгууллагуудын ажилтнуудынхаа чадавхийг нэмэгдүүлэхэд онцгой анхаарч ажилласан билээ.

Түүний дараа 1999 оноос хөтөлбөрийн 2 дахь захирлаар томилогдон ирсэн ноён Марк Лапорт нь ХИС-г байгууллагын хувьд улам бэхжүүлж, боловсон хүчний нийгмийн асуудлыг сайжруулах, хандивлагчдын хүрээг өргөжүүлэх, шинээр хэрэгжиж байгаа хөтөлбөрүүдийг дэмжих талаар их зүйлийг хийсэн юм. Ийнхүү манай сан жилээс жилд өргөжин тэлж, нийслэл Улаанбаатарт төвлөрөөд зогсохгүй, орон нутагт тухайлбал Чойбалсан хотод салбараа нээж нийт 60 гаруй ажилтан ажиллагсадтайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.



ХИС (Англи) нь байгуулагдсан цагаасаа Монгол Улсын төрийн болон төрийн бус байгууллагуудтай үйл ажиллагаагаа уялдуулан хамтран ажиллаж байна. Тухайлбал 1995 оноос Хүн Амын Бодлого Хөдөлмөрийн Яам (хуучин нэрээр), Ядуурлыг Бууруулах Үндэсний Газартай “Ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөр,” БСШУЯ-тай “Сургуулийн өмнөх боловсролын үндэсний хөтөлбөр”, БСШУЯ, УБИС-тай “Нийгмийн ажлын хөтөлбөр,” Хүүхдийн Төлөө Үндэсний Газартай тус газрын “стратегич төлөвлөлт” дээр хамтран ажиллаж санхүүгийн дэмжлэг үзүүлэхээс гадна агуулга арга зүйн зөвлөгөө өгөх замаар туслалцаа үзүүлэх зэргээр Монголын хүүхэд багачуудын төлөө олон хөтөлбөр төслүүдийг хэрэгжүүлж ирлээ. Энэхүү арван жилд ХИС-аас хэрэгжүүлсэн болоод хэрэгжүүлж буй хөтөлбөрүүдийг цогц байдлаар үзүүлье.

Хөтөлбөрийн нэр	Хэрэгжсэн он	Гол онцлог үйл ажиллагаа
Сургуулийн өмнөх боловсрол	1994 оноос одоог хүртэл	Сургуулийн Өмнөх боловсролын нөхцөл байдлын судалгааны ажлыг санхүүжүүлсэн. Сургуулийн өмнөх боловсролын үндэсний хөтөлбөр –1-ийг боловсруулах, хэрэгжүүлэхэд оролцон санхүүжүүлсэн. “СӨБ- 2” үндэсний хөтөлбөр хэрэгжүүлэхэд оролцсон. СӨБ-ын агуулгын үлгэрчилсэн цөм хөтөлбөр боловсруулсан. СӨБ-ын төвүүдийг байгуулахад дэмжлэг үзүүлж хамтран ажилласан. БСШУЯ-ны дэргэд “Тэгш хамруулан сургах боловсролын нэгж” байгуулсан. Хүүхэд төвт сургалт, сургалтын идэвхитэй аргуудыг нэвтрүүлэх, хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлсэн. “Хүүхэд ээлтэй цэцэрлэг”, Боловсролд тэгш хамруулан сургах” үзэл баримтлалыг дэлгэрүүлэхэд БСШУЯ болон холбогдох байгууллагуудтай идэвхтэй ажилласан.
Хүүхдийн Төлөө Үндэсний Төв сургалтын программ	1994-1995	ХТҮТ-ийн Хүүхдийн Төлөө Үндэсний Төв, Хотын Хүүхдийн Төлөө Газар НХТ-тэй хамтран хүүхдийн байгууллагын анхан шатны 500 гаруй ажилтнуудад зориулан нийгмийн хөгжил, хүүхдийн эрх, хүүхэд төвт хөгжлийн чиглэлийн сургалтын хөтөлбөр боловсруулан 18 аймаг 3 хотод сургалтуудыг зохион байгуулж, ажилтнуудад эмзэг бүлгийн хүүхдүүдтэй ажиллах чадавхийг бий болгоход чиглэгдсэн арван туршилтын төслүүдийг хэрэгжүүлсэн.
Ядуурлыг Бууруулах Үндэсний Хөтөлбөрийн чадавхийг бэхжүүлэх	1995-2000	Ядуурлыг Бууруулах Үндэсний Газартай хамтран ЯБҮХ-ийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг ханган, Нийгмийн хөгжлийн төвийг санаачлан байгуулж нийгмийн хөгжлийн чиг хандлагыг танилцуулах сургалтын хөтөлбөр боловсруулан сургалтыг орон даяар явуулсан. Мониторинг Үнэлгээний Системийг боловсруулсан. Өрх толгойлсон эхчүүдийг дэмжих төсөл, Малжуулах, “ЯБҮХ-ийн хүрээнд СӨБ-ыг бэхжүүлэх” төслүүдийг хэрэгжүүлсэн.
Хараа хяналтгүй хүүхэд	1995- одоог хүртэл	Монгол улсын Засгийн газрын уриалгын дагуу хараа хяналтгүй хүүхдүүдийг түр байрлуулах халамжийн 10 төвийг Улаанбаатар, Чойбалсан, Дархан, Сүхбаатар, Зуунмод хотуудад, өдрөөр үйлчлэх төвүүдийг Улаанбаатар, Чойбалсан хотуудад тус тус байгуулсан. ХТҮГ-аас зохион байгуулсан Халамжийн байгууллагын жишиг стандарт боловсруулах ажлын хэсэгт ажиллаж байна. Мөн олон нийтэд түшиглэсэн төвүүдийг байгуулах ажлыг санаачлан байгуулж эхлээд байна. УБИС-ийн нийгмийн ажлын тэнхимтэй хамтран хүнд нөхцөлд амьдардаг хүүхдүүдтэй ажиллах боловсон хүчний чадавхийг нэмэгдүүлэх сургалтын хөтөлбөрийг боловсруулан, гарын авлага бэлдэн, шаталсан сертификатын сургалтуудыг зохион байгуулсан.
Хөдөлмөр ба Хүүхэд	1996 оноос одоог хүртэл	Хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдийг боловсролд хамруулах ажлыг дэмжин, мэргэжлийн чиг баримжаа олоход нь дэмжлэг үзүүлэх “Сурч-хөдөлмөрлөө” үйл ажиллагааны хөтөлбөр хэрэгжүүлсэн, техник мэргэжлийн сургуулиудын материаллаг баазыг бэхжүүлж, хөдөлмөр эрхэлдэг хүүхдийн “Мандах” холбоог байгуулж, үйл ажиллагааг нь дэмжиж байна. Хөдөлмөр эрхэлдэг хүүхдүүдийн нөхцөл байдал, байршлыг тодорхойлох хэд хэдэн судалгааг хийсэн.
Нийгмийн ажлын боловсрол	1996-2001	МУБИС дээр нийгмийн ажлын тэнхим, Дорнод дахь Багшийн коллеж, МУИС-ийн Ховд аймаг дахь салбар их сургуульд нийгмийн ажлын сургалт судалгаа арга зүйн төвүүдийг тус тус байгуулсан. Нийгмийн ажлын багш нарыг бэлтгэх, олон улсын нийгмийн ажлын бусад их дээд сургуулиудтай холбоо тогтоох, нийгмийн ажлын сургалтын хөтөлбөрийг боловсруулахад санхүүгийн болон техникийн тусламж үзүүлсэн. Монголын нийгмийн ажилтны нийгэмлэг үүсгэн байгуулсан.
Сургуулийн нийгмийн ажилтан	1996-2002	Сургууль завсардалтыг багасгах зорилгоор нийгмийн ажлын үйлчилгээг боловсролын тогтолцоонд бий болгох туршилтын төслүүдийг хэрэгжүүлсэн. БСШУЯ-ны бага дунд тусгай боловсролын газрын дэргэд Сургуулийн нийгмийн ажилтны нэгж байгуулан, 2000 оноос ЕБС-д нийгмийн ажилтан ажиллаж эхэлсэн.
ДОХ/БЗХӨ-с урьдчилан сэргийлэх сургалт	1997-2001	ДОХ/БЗХӨ-ний талаар хүүхдэд зориулсан хялбаршуулсан сургалтын хөтөлбөр, гарын авлага боловсруулсан. “Амьдрах ухаан” сургалтыг явуулах хөтөлбөр боловсруулан, сургалтыг явуулах үе тэнгийн сургагч нарыг
Хүүхдийн эсрэг хүчирхийлэл ба хамгаалал	2000 оноос одоог хүртэл	Хүчирхийллийн Эсрэг Үндэсний Төв дээр Хүүхдийн хамгааллын нэгж байгуулсан. Хүүхдийн эсрэг хүчирхийллийн талаар олон нийтийн мэдлэгийг нэмэгдүүлэх, хүчирхийллийн талаархи хэвшмэл үзлийг эвдэх, хүнд нөхцөлд амьдардаг хүүхдийн эрхийг хангах, ТББ-уудын чадавхийг бэхжүүлэх зэрэг төрийн болон ТББ-уудын үүсгэл санаачлагыг дэмжин санхүүжүүлж ирсэн.
Байгалийн гамшгийн үр дагаврыг бууруулах	2000 оноос одоог хүртэл	ХИС нь гамшгийн үр дагаврыг бууруулах бэлэн байдлын хөтөлбөрөө боловсруулсан. Хүүхэд ба төрөх насны эмэгтэйчүүдийн дунд хоол тэжээлийн байдлын судалгаа хийсэн. Байгалийн гамшигт нэрвэгдсэн Ховд, Баянхонгор, Дорнод, Дундговь аймгуудад төсөл хэрэгжүүлсэн.

Дээрх хөтөлбөрүүдийн үр дүнд Монгол улсад нийгмийн хөгжлийн шинэ чиг хандлагыг төлөвшүүлэх, ядуурлыг бууруулах, хүүхдийг ялангуяа эмзэг бүлгийн хүүхдийг боловсролд тэгш хамруулахад шаардлагатай гэр бүлийн болоод нийгмийн орчин бүрдүүлэх, багшлах боловсон хүчний чадавхийг нэмэгдүүлэх, орчин үеийн нийгмийн ажилтан бэлтгэх үндэс суурийг тавих, хүүхдийн эсрэг хүчирхийллийг бууруулах, хараа хяналтгүй хүүхдүүдийг түр орон байраар хангах, тэднийг амьдралд бэлтгэх, гэр бүлийг дэмжих зэргээр боловсролын болоод нийгмийн салбарт олон бодитой ажил хийгээд байна.

1994 оноос 2004 оныг хүртэлх хугацаанд дээрх хөтөлбөр төслийг хэрэгжүүлэхэд нийтдээ 4,2 сая фунт стерлинг буюу тухайн үеийн ханшаар 6 тэрбум 490 сая төгрөг зарцуулжээ.

ХИС-ийн үйл ажиллагааг түүнийг дэмждэг санхүүжүүлэгч, хандивлагчгүйгээр төсөөлөхийн аргагүй бөгөөд энэ хугацаанд **Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын Монгол дахь Элчин Сайдын Яам** манай гол хандивлагч байсаар ирсэн.

ХИС нь өөрийн үйл ажиллагааг нээлттэй, хүүхдийн бодит хэрэгцээнд тулгуурлан явуулахыг зорьж ирсэн бөгөөд хэрэгжүүлсэн хөтөлбөр төслийн үнэлгээг гадаад дотоодын шинжээчдийн оролцоотой хийж тэдний саналыг тусган байнга шинийг эрэлхийлэн ажилладаг юм. Үүний үрээр манай хөтөлбөр төслүүд амжилттай хэрэгжиж, үр шим нь хүртэх ёстой хүүхдүүддээ шууд хүрч байдаг нь бид сэтгэл хангалуун явдаг билээ.

ХИС-ийн үйл ажиллагааг Монгол улсын Засгийн Газар, хамтран ажиллагч байгууллагууд өндрөөр үнэлэн

- 1999 онд Нийслэлийн Хүүхдийн Төлөө Зөвлөлийн “Өргөмжлөл”
- 2000 онд МХТҮГ-ын “Хүндэт Өргөмжлөл”
- 2000 онд Монгол Улсын Цагдаагийн Ерөнхий Газрын “Хүндэт өргөмжлөл”
- 2001 онд “Кёкүшюзан хөгжил сан”-ийн “Оны шилдэг олон улсын ТББ” өргөмжлөл, “Монголын төлөө хүчин зүтгэсний учир” цом өргөмжлөл
- 2003 онд Нийслэлийн засаг даргын “Хүүхдэд ээлтэй байгууллага” өргөмжлөл, Дундговь, Ховд зэрэг аймгуудын засаг даргын тамгын газрын өргөмжлөлөөр тус тус шагнасан байна. Мөн ХИС-ийн анхны суурин төлөөлөгч Жон Боклер Монгол улсын Засгийн Газрын “Найрамдал” медалиар энгэрээ мялааж, манай олон ажилтнууд бусад байгууллагуудын өргөмжлөл, медаль, хүндэт тэмдгүүдээр шагнагдаж ирснийг дурьдахад бахархалтай.

ХИС үйл ажиллагааныхаа тулгуур болсон боловсон хүчнээ хөгжүүлэхэд ихээхэн анхаарал тавьж, гадаадад боловсролоо дээшлүүлэх, зэрэг цол хамгаалахад нь байнга дэмжлэг үзүүлж ирсний үр дүнд манайд доктор, докторант, АНУ, Их Британи зэрэг улсуудад нийгмийн болон бусад салбарын чиглэлээр суралцсан магистр цолтой ажилтнууд ажиллаж ирсэн.

Өнгөрсөн 10 жилийн хугацаанд ХИС (Англи) үндсэн хоёр стратеги төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж, 2004 оноос хэрэгжүүлэх гурав дахь стратеги төлөвлөгөөгөө түншлэн ажилладаг байгууллагууд, бидний ажлын үр шимийг хүртэгч нартай хамтран боловсруулаад байна. Энэхүү 3 дахь зорилго бид :

- Хүүхдийн эрхэд тулгуурласан бодлогын хүрээнд хөтөлбөр хоорондын болон хамрах орон нутаг дахь үйл ажиллагааны хоорондын уялдааг сайжруулах,
- Хүүхэд хамгааллын хэлбэрийг сонгохдоо эрх нь зөрчигдсөн хүүхдүүдийг илүү өргөнөөр хамарч тусламж үзүүлэх боломжтой хэлбэрүүдэд төвлөрөх,
- Олон нийтээс гарах санаачилгыг түлхүү дэмжих, сонирхогч талуудын, ялангуяа хүүхдийн идэвхтэй оролцоог өрнүүлэх,
- Хүүхэдтэй холбоотой бүх салбарт хүүхдийн асаргаа, хамгааллыг чанарын өндөр түвшинд хэрэгжүүлэх талаар нөлөөллийн ажил хийхэд чиглүүлэхээр төлөвлөөд ажилдаа урам зориг дүүрэн ороод байна.

Энэ 10 жилийн хугацаанд бидний ажил үйлсийг дэмжин, ямагт хамтран ажиллаж ирсэн Монгол Улсын Засгийн Газар, түүний агентлагууд, төрийн бус байгууллагууд, үйл ажиллагааг маань тэтгэн санхүүжүүлэгч, хандивлагч байгууллагууд болох Элчин Сайдын Яамдууд, хөгжлийн агентлагууд, НҮБ-ын Хүүхдийн Сан, олон улсын төрийн бус байгууллагууд болон зорилго нэгт бүх хүмүүст дахин талархал илэрхийлж, тавьсан зорилго, тэмүүлсэн амжилтандаа хүрч улам ихийг бүтээхийг хүсэн ерөөе.

ХИС (Англи)-ийн
Захиргааны Менежер Л. Дулмаа

Хөтөлбөрийн нэр: БОЛОВСРОЛ

Хөтөлбөрийн зорилго: Боловсролын байгууллагыг бэхжүүлэх, сургалтын агуулга арга зүйг шинэчлэн боловсронгуй болгох, багш төвтэй сургалтаас хүүхэд төвтэй сургалтанд шилжих

Хөтөлбөрийн зорилт:

Сургуулийн өмнөх боловсрол үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн жилүүдэд цэцэрлэгт хамрагдах хүүхдийн тоог 20 – 80 хувь хүртэл өсгөх, төрийн ба төрийн бус өмчийн цэцэрлэгүүдийн үйл ажиллагааг дэмжих, сургуулийн өмнөх боловсролын агуулга арга зүйг шинэчлэн боловсруулах, сургуулийн өмнөх боловсролын салбарт ажиллагсдын чадавхийг дээшлүүлэх тэднийг бэлтгэх, давтан бэлтгэх; эмзэг бүлгийн хүүхдийн боловсролыг дэмжих, малчдын хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд хамруулах, сургуулийн өмнөх насны хүүхдийн сургалтын хэрэглэгдэхүүн, тоглоом наадгайн хангамжийг сайжруулах зэрэг 8 үндсэн зорилтыг дэвшүүлжээ.



Нийслэлийн 67-р цэцэрлэг
Бид зурж бүтээх шинэ арга барилд суралцаж байна.

Үйл ажиллагаа, үр дүн

- Сургуулийн өмнөх боловсролын талаархи мэдлэг, мэдээллийг олон нийтэд түгээн дэлгэрүүлснээр орон нутгийн засаг захиргаа, эцэг эх, олон нийт, орон нутгийн байгууллагуудын зүгээс СӨБ-д хандах хандлага өөрчлөгдсөн.
- Цэцэрлэгийн үйл ажиллагааг багш төвтэйгээс хүүхэд төвтөйд шилжүүлэх үндсэн нөхцөл болох сургалтын агуулга арга зүйд өөрчлөлт хийж чадсан. Үүний үр дүнд хүүхэд төвтэй хөгжлийн онол арга зүйд тулгуурласан “Сургуулийн өмнөх боловсролын агуулгын үлгэрчилсэн цөм хөтөлбөр”-ийг боловсруулж үндэсний түвшинд мөрдөж байна.
- Сургуулийн өмнөх боловсролын салбарт ажиллаж буй багш нарын 55 хувь нь төвлөрсөн байдлаар Улаанбаатар хотод, 45 хувь нь орон нутагтаа давтан сургалт буюу мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдсан.
- Малчдын, алслагдсан нутгийн ба нийгмийн эмзэг бүлгийн хүүхдэд зориулсан ээлжийн бүлэг, явуулын багш, зуны болон бямба, ням гаригийн сургалт гэх мэт сургалтын олон шинэ арга хэлбэрийг амьдралд нэвтрүүлсэн.
- Зарим нэг зайлшгүй шаардлагатай цэцэрлэгүүдийн барилгын урсгал засвар болон халаалтын асуудлыг шийдвэрлэжээ.
- Сургуулийн өмнөх боловсролын салбарын багшлах хүчнийг бэлтгэх давтан бэлтгэх арга зүй шинэчлэгдсэн.
- “Сургуулийн өмнөх боловсрол үндэсний хөтөлбөр-1” ийн үнэлгээний тайланд үндэслэн БСШУЯ “Сургуулийн өмнөх боловсрол-2” үндэсний хөтөлбөрийг боловсруулсан нь Монгол улсын Засгийн газраас батлагдаж 2000 – 2007 онд сургуулийн өмнөх боловсролын салбарт хэрэгжүүлэхээр болсон. Энэхүү хөтөлбөрийн хэрэгжилтэд Хүүхдийг Ивээх Сан тодорхой үүрэгтэйгээр оролцож байна.

Хүүхдийг Ивээх Сангийн Боловсролын хөтөлбөр нь өнгөрсөн 10 жилд үйл ажиллагаа нь өргөжсөн төдийгүй агуулгын хувьд хүрээгээ тэлж байна. Анх 1994-1995 онд сургуулийн өмнөх боловсролын салбарт идэвхтэй үйл ажиллагаа өрнүүлж байсан бол өнөөдөр сургуулийн өмнөх ба бага боловсрол, албан бус боловсрол, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролын асуудлаар төрийн ба төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллаж байна.

Хүүхдийг Ивээх Сангийн “Боловсрол” хөтөлбөр нь дараах 2 дэд хөтөлбөрийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Хөтөлбөрийн нэр : 1. Сургуулийн өмнөх боловсрол

Хөтөлбөрийн зорилго :

“Монгол улсын сургуулийн өмнөх боловсролын салбарын өөрчлөлт, шинэчлэлтийг дэмжих замаар боловсролын хүртээмжийг нэмэгдүүлж, чанарыг сайжруулахад оршино.

Үйл ажиллагаа, үр дүн

а. Сургуулийн өмнөх боловсролын агуулга арга зүйн төвийн үйл ажиллагааг дэмжих: Хөдөө орон нутаг, сум, хотын захын хороололд ажиллаж буй багш нарыг мэргэжил дээшлүүлэх сургалтад олноор хамруулах, сургуулийн өмнөх боловсролын агуулгын үлгэрчилсэн цөм хөтөлбөрийн хэрэгжилт болон хүүхэд төвт сургалтын үйл ажиллагааны чанарыг сайжруулах, сургуулийн өмнөх боловсролын чиглэлээр гарч буй ном, сурах бичиг, гарын авлага, зөвлөмжийн хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр үйл ажиллагааг зохион байгуулж байна. Хүүхдийг Ивээх Сангийн дэмжлэгтэйгээр Боловсролын Хүрээлэн дээр сургуулийн өмнөх боловсролын төв ажиллаж байна. Сургуулийн өмнөх боловсролын төвийн үйл ажиллагааг орон нутагт хүргэх ажлын хүрээнд Ховд, Баян-Өлгий, Дундговь, Баянхонгор зэрэг аймгуудад тухайн аймгийн Боловсрол соёлын газрын дэргэд Сургуулийн өмнөх боловсролын төвүүд ажиллаж байна. Дээрх аймгууд дахь төвүүд нь эхний ээлжинд өөрийн аймгийн хүрээнд үйл ажиллагаа явуулах ба улмаар бүсийн төв болж ажиллах хэтийн төлөвлөгөөтэй юм.

б. Эмзэг бүлгийн хүүхдүүдийн боловсролыг дэмжих, гэр цэцэрлэг байгуулах, Хүүхдийг Ивээх Сан нь эмзэг бүлгийн хүүхдийн боловсролыг дэмжих ажлын хүрээнд аймаг, сум, хотын захын хороололд гэр цэцэрлэг байгуулах ажлыг 1995 оноос эхлэн зохион байгуулж, энэ чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж байна. Хүүхдийг Ивээх Сан нь үндсэн хоёр зорилгын үүднээс гэр цэцэрлэгийг байгуулахад дэмжлэг үзүүлж байна. Үүнд: 1-рт сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж чадахгүй байгаа 3-8 насны хүүхдүүдийг цэцэрлэгт хамруулах, 2-рт орон нутгийн иргэд /олон нийт, эцэг эхчүүд/ төрийн захиргааны болон төрийн бус байгууллагуудын үүсгэл санаачлагыг дэмжихэд оршино.

Гэр цэцэрлэг нь бага насны хүүхдүүдэд сургуулийн өмнөх боловсрол олгох, эцэг эхийн сурган хүмүүжүүлэх мэдээллийг баяжуулах, нутгийн иргэдийг гэгээрүүлэх гэсэн гурван үндсэн чиглэлийн үйл ажиллагааг зохион байгуулдаг.

1995 – 2002 онд зөвхөн гэр цэцэрлэгээр Хүүхдийг Ивээх Сангийн дэмжлэгтэйгээр 1600 гаруй хүүхэд сургуулийн өмнөх боловсролыг эзэмшээд байна.

2000-2004 онуудад “Сургуулийн өмнөх боловсрол” хөтөлбөрийн үйл ажиллагааг илүү нарийвчилсан, тодорхой зорилтуудыг дэвшүүлсэн. Тухайлбал, тус хөтөлбөр нь эмзэг бүлгийн хүүхдийн боловсролыг дэмжих, ялангуяа ядуу, тахир дутуу хүүхдүүд, алслагдсан сум, дүүргийн хүүхдүүдийг олноор сургуулийн өмнөх боловсролд хамруулахад үйл ажиллагааг голлон чиглүүлж ажиллаж байна.

в. Сургуулийн өмнөх боловсролын чанарыг сайжруулах хүүхдэд ээлтэй боловсролыг дэмжих

2000 оноос эхлэн Хүүхдийг Ивээх Сангийн “Сургуулийн өмнөх боловсрол” хөтөлбөр нь боловсролын чанарыг сайжруулахад хөтөлбөрийн үйл ажиллагааны тодорхой хэсгийг чиглүүлж байна. Тухайлбал цэцэрлэгүүдийн сургалтын орчинг сайжруулах, тоглоом наадгай, сургалтын хэрэглэгдэхүүний хүртээмжийг нэмэгдүүлэх хүүхэд багштайгаа, хүүхэд эцэг эхтэйгээ, хүүхэд хүүхэдтэйгээ харилцах харилцааг эерэг хандлагаар хөгжүүлэх, цэцэрлэг гэр бүлд Хүүхдийн эрхийн конвенцийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зэргээр төсөл хэрэгжүүлэхэд нь нэгж байгууллага, хамт олонд дэмжлэг үзүүлж хамтран ажиллаж байна.

Хөтөлбөрийн нэр: 2. Боловсролд тэгш хамруулан сургах

Хөтөлбөрийн зорилго: Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг боловсролд тэгш хамруулан сургах боломжийг нэмэгдүүлэх, үндэсний бодлого боловсруулахад ХИС-гийн гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх

Үйл ажиллагаа, үр дүн

Боловсролд тэгш хамруулан сургах дэд хөтөлбөр нь Хүүхдийг Ивээх Сангаас хэрэгжүүлж буй боловсролын хөтөлбөрийн хэрэгжилтийн хөгжлийн явцад төслийн үр шимийг хүртэгчдийн хэрэгцээнээс урган гарч ирсэн зайлшгүй хийгдэх шаардлагатай үйл явц юм.

Энэхүү хөтөлбөр нь 1998 оноос биеэ даасан дэд хөтөлбөр болсон төдийгүй үйл ажиллагаа нь дараах үндсэн чиглэлтэй. Үүнд:

Хөгжлийн бэрхшээлтэй бага насны хүүхдийг боловсролд тэгш хамруулах нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр холбогдох яамд байгууллагуудтай хамтран ажиллах

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамрах хууль эрх зүйн нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр БСШУЯ-тай хамтран ажиллах

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн боловсролыг дэмжих чиглэлээр эцэг эх, олон нийт, төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах, тэдэнд дэмжлэг үзүүлэх

Боловсролд тэгш хамруулан сургах дэд хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд тэдний багш сурган хүмүүжүүлэгчид, эцэг эхчүүдийг өргөн хүрээтэй хамруулан тэднийг системтэй сургалтад хамруулах, ном гарын авлага, шаардлагатай нөхцөлд туслах хэрэгслээр хангах зэргээр үйл ажиллагааг нөхцөл байдалд нийцүүлэн зохион байгуулж ажиллаж байна.

Боловсролд тэгш хамран сургах дэд хөтөлбөр нь үйл ажиллагаагаа төслийн хүрээгээр хязгаарлах бус хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг тэгш хамран сургах үзэл санааг үндэсний түвшинд нэвтрүүлэх хэрэгцээ шаардлага байгааг харгалзан үндэсний түвшний бодлого боловсруулахад ихээхэн анхаарал тавьж ажиллаж байна. Тухайлбал, БСШУЯ-д “Тэгш хамруулан сургах боловсролын нэгж”-ийг байгуулахад дэмжлэг үзүүлж, тус нэгжтэй нягт хамтран ажиллаж байна.

Санхүүжүүлэгч байгууллага:

Их Британы ЭСЯ, Канад сан, Канадын “Ди анд Жи” сан, Европын холбооны “ТАСИС” хөтөлбөр, Жерсийн Олон улсын тусламжийн Хороо, Гүрсийн ОУТХ

Санхүүжилт: 1997 оноос тооцсон дүнгээр 770,300 фунд стерлинг буюу 1 тэрбум 194 сая төгрөг

Хэрэгжсэн газар: Үндэсний ба орон нутгийн түвшинд

Аймгууд: Баянхонгор, Баян-Өлгий, Ховд, Увс, Дорнод, Говь-Алтай, Төв, Дундговь, Дархан-Уул, Өмнөговь

Хамтран ажиллагч байгууллагууд:

- БСШУЯ, МУБИС-ийн Сургуулийн өмнөх боловсролын сургууль
- Боловсролын Хүрээлэн Сургуулийн өмнөх боловсролын төв
- Аймаг хотын Боловсрол Соёлын Газрууд
- Монголын Нээлттэй Нийгэм-Хүрээлэн Соросын Сан
- Дэлхий зөн олон улсын байгууллага
- Хөгжлийн Бэрхшээлтэй Хүүхэдтэй Эцэг Эхийн Холбоо
- Монгол Хүүхэд Судлалын Хүрээлэн
- “Өүлэн ээж” төв ТББ, Цэцэрлэг, сургууль, олон нийт, гэр бүл, эцэг эх



Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд боловсрол эзэмших эрхтэй.

Хөтөлбөрийн нэр: ЯДУУРЛЫГ БУУРУУЛАХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ЧАДАВХИЙГ БЭХЖҮҮЛЭХ

Хөтөлбөрийн зорилго: Нийгмийн хөгжлийн тухай орчин үеийн түлхүүр ойлголт, орон нутгийн иргэдийн оролцоо нь нийгмийн хөгжилд ямар үүрэгтэй байх талаар олон нийтийн дунд мэдлэг бий болгох, нийгмийн хөгжил дэх оролцооны зарчмыг Монголын Засгийн газраас 1994-2000 онуудад хэрэгжүүлсэн Ядуурлыг Бууруулах Үндэсний Хөтөлбөрийн үйл ажиллагааны үндсэн зарчмын нэг болгон төлөвшүүлэх замаар ЯБҮХГ болон түүний орон нутаг дах салбар зөвлөлүүдийн чадавхийг бэхжүүлэх, оролцооны зарчимд суурилсан мониторинг үнэлгээний системийг нэвтрүүлэх.



ЯБҮХГ, Нийгмийн Хөгжлийн Төвтэй хамтран "Малжуулах" төслийн хэрэгцээг судлах ажиллагаа 1997 он, Архангай аймаг

Хэрэгжсэн хугацаа: 1994- 2000 он

Хамтран ажиллагч байгууллагууд:

Хүн Амын Бодлого Хөдөлмөрийн Яам (хуучин нэрээр),
Ядуурлыг Бууруулах Үндэсний Газар,
Нийгмийн Хөгжлийн Төв

Санхүүжүүлэгч: Их Британы ЭСЯ-ны Түншлэлийн Хөтөлбөр, Азийн Хөгжлийн Банк, НҮБ-ийн Хөгжлийн Хөтөлбөр

Үйл ажиллагаа, үр дүн

ХИС нь 1995 оноос ЯБҮГ-тай хамтран Ядуурлыг Бууруулах Үндэсний Хөтөлбөрийн анхны бичиг баримтыг боловсруулах бэлтгэл ажилд бүх хот, орон нутгийн Төрийн болон ТББ-ийг татан оруулж, тэдэнтэй хийсэн цуврал уулзалтаар улс оронд нүүрлээд байсан ядуурлыг хэрхэн бууруулах талаар хэлэлцүүлж, үүнд орон нутгийн төлөөлөгчдийн оролцоог хангахад анхаарч ажилласан нь ЯБҮХ-ийн баримт бичгийг боловсруулан эцэслэхэд ихээхэн хувь нэмэр өгч, орон нутгийн дуу хоолойг уг баримт бичигт тусгаж чадсан.

1995-1997 онуудад ЯБҮХГ, түүний орон нутаг дах салбар зөвлөлийн гишүүдийн эмзэг бүлгийн хүмүүстэй ажиллах ур чадварыг бий болгох, хандлагыг өөрчлөх, нийгмийн хөгжлийн чиг хандлагыг таниулах "Нийгмийн Хөгжил" сэдэвт сургалтуудыг үндэсний болон орон нутгийн түвшинд зохион явуулж, орон нутгийн сургагч нарыг бэлтгэсэн. ХИС-ийн санаачлага, техник туслалцаа, санхүүгийн дэмжлэгтэйгээр Монгол улсын хэмжээнд нийгмийн хөгжлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж эхэлсэн анхны ТББ болох "Нийгмийн хөгжлийн төв" байгуулагдсан ба тэрээр өнөөг хүртэл 10 жилийн хугацаанд тасралтгүй үр бүтээлтэй ажиллан олонд танигдсан, бие даасан чадварлаг байгууллага болон төлөвшсөн. Энэхүү төсөлд нийтдээ 175,500 ам.долларын санхүүжилтийг ХИС (Англи), НҮБ-ийн Хөгжлийн Хөтөлбөр, Олон Улсын Хөдөө Аж Ахуйн Хөгжлийн Сангийн хамтарсан хөрөнгө оруулалтаар хийсэн.

1997-1999 ЯБҮХ-ийн хэрэгжилтийг сайжруулах зорилгоор ЯБҮХ-ийн хүрээнд хэрэгжиж байгаа төслүүдийн явцыг оролцооны аргаар үнэлэх Мониторинг Үнэлгээний Системийг боловсруулан нэвтрүүлэх төслийг Азийн Хөгжлийн Банкны (220,000 ам.доллар) санхүүжилтээр хэрэгжүүлэв.

1997-1999 онуудад Олон улсын хөдөө аж ахуйн хөгжлийн сангийн дэмжлэгтэйгээр хэрэгжиж эхэлсэн "Хөдөөгийн ядуурлыг бууруулах" хөтөлбөрийн малжуулах төслийн орон нутаг дахь хэрэгцээг үнэлэх үнэлгээг хийсэн.

Улмаар ХИС ЯБҮХ-ийн хүрээнд Английн Түншлэлийн Хөтөлбөртэй хамтран дараах дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж ирлээ. Үүнд:

Хөтөлбөрийн нэр: 1. “Өрх толгойлсон эхчүүдийг дэмжих төсөл”

Хэрэгжсэн газар: Өмнөговь, Дорнод, Сүхбаатар, Дархан-Уул

Хэрэгжсэн хугацаа: 1998-1999

Хөтөлбөрийн зорилго: Бага насны олон хүүхэдтэй өрх толгойлсон эхчүүдийн өрхийн орлого нэмэгдүүлэх үйл ажиллагааг дэмжих, зээл олгосон эхний 5 сарын хугацаанд эхийг нь ажиллах боломжоор хангах, хүүхдийг хөгжүүлэх, эрүүл энх өсгөх зорилгоор хүүхдийн хоолны болон тоглоомын мөнгийг төслийн санхүүжилтээр олгох

Үйл ажиллагаа, үр дүн:

Орон нутагт үйл ажиллагаа явуулдаг ТББ-аар дамжуулан төсөлд хамрагдсан өрх толгойлсон эмэгтэйчүүдэд богино хугацаанд бизнесийн анхан шатны мэдлэг олгох, өрхийн орлого нэмэгдүүлэх үйл ажиллагааны арга барилд суралцуулах сургалтуудыг зохион байгуулж улмаар сонгогдсон ТББ-ууд уг төслийн идэвхжүүлэгчээр ажилласан нь төслийн анхан шатан дахь хэрэгжилтийг сайжруулах, тухайн ТББ-ын чадавхийг бэхжүүлэхэд ихээхэн хувь нэмэр болсон.

Төслийн хүрээнд 256 эх өрхийн орлогоо нэмэгдүүлэхээр жижиг зээлд хамрагдан ногоо тарьж, жижиг үйлдвэрлэл эрхлэн, үйлчилгээ явуулсан. Тэд ихэвчлэн оёдол, гутал засвар, сүлжмэл, савхин эдлэлийн жижиг үйлдвэрлэл, дархан, мужаан, цайны газар, үсчин, зэрэг үйлчилгээний газруудыг ажиллуулж, жижиг худалдаа эрхлэх зэргээр амьдрал ахуйгаа дээшлүүлсэн юм.

Орлого нэмэгдүүлэх төсөлд хамрагдсан эхчүүдийн ажиллах боломжийг хангах зорилгоор нийт 313 хүүхдийг шинээр сургуулийн өмнөх боловсролд хамруулан тэдний цэцэрлэгийн хоолны мөнгөний эцэг эхээс төлөх хувийг 6 сарын хугацаатай төслийн санхүүжилтээр төлөн нэг удаа хувцас, хичээлийн хэрэгслээр хангасан билээ. Төслийн хугацаанд хүүхдүүдийг хүлээн авч ажилласан 6 сумын цэцэрлэг тус бүрийн 2-3 бүлгийг тоглоомоор хангасан.



Төслийн тайлангийн ажиллагаа, Сонгино-Хайрхан дүүрэг

Санхүүжүүлэгч: Их Британы ЭСЯ-ны Түншлэлийн Хөтөлбөр

Санхүүжилт: 34, 420 мянга фонд буюу 53 сая 339 мянган төгрөг

Хөтөлбөрийн нэр: 2. “Малжуулах”

Хэрэгжсэн газар: Баян-Өлгий, Баянхонгор, Дорнод, Хөвсгөл, Увс, Сүхбаатар,

Хэрэгжсэн хугацаа: 1998-2000

Зорилго: Ган зудад нэрвэгдэн малаа их хэмжээгээр алдсан, бага насны олон хүүхэдтэй, эргэлтийн малгүй айл өрхөд зээл олгох замаар өрхийн орлогыг нэмэгдүүлэх, ядуу малчдын хүүхдийн сургууль завсардалтыг бууруулах

Үйл ажиллагаа, үр дүн:

1998-1999 онуудад нийт 268 ядуу өрх мал хүлээн авснаас Баян -Өлгий, Хөвсгөл, Дорнод, Баянхонгор аймгийн өрхүүд тус төсөлд хамрагдсан байна.

1998 хавар Баян-Өлгий аймагт нийтдээ 1522 толгой мал өрхүүдэд зээлээр олгосон бөгөөд 1999 оны хавар гэхэд 2635 болон өссөн байна.

1999-2000 онуудад нийт 202 өрх буюу Дорнод, Увс, Сүхбаатар аймгийн өрхүүд тус тус хамрагдсан. Сүхбаатар аймагт малжуулахаар олгогдсон 1509 толгой мал дараа хавар нь 2805 болон өссөн дүн гарчээ. Ядуу өрхийн малын тоо толгой өссөнөөс гадна малаас гарах ашиг шимийг зарж борлуулснаас өрхийн орлого нэмэгдсэн юм. Жишээ нь: Сүхбаатар аймгийн Дарьганга сумын 25 өрх нийтдээ 1,7 сая төгрөгөөр орлого нь нэмэгдсэн байна.

Төсөлд хамрагдсан өрхийн малын тоо толгой өсөн, өрхийн орлого нэмэгдэхийн чацуу, гишүүд мал маллах талаар болон, малын ашиг шимийг хэрхэн нэмэгдүүлэх, зах зээл дээр яаж борлуулах талаар сургалтанд хамрагдан, өрхийн орлого зардлаа тооцож сурчээ. Төслийг хэрэгжүүлэх ажлыг орон нутагт зохион байгуулсан төслийн багийн гишүүд нь малжуулах ажлыг орон нутагт зохион явуулах аргачлалд суралцсан. Тэд малын тендер, зарлах, мал олгох, малжуулах өрхийг оролцооны зарчмын үндсэн дээр сонгон авах, малчдын дунд чадавхжуулах сургалт явуулах, туршлага солилцуулах уулзалтуудыг зохион явуулсан байна. ЯБУХ-ийн хэрэгжилтийг хөдөөгийн олон өрхөд хандуулж чадсан нь уг төслийн гол амжилт байсан.

Санхүүжүүлэгч: Их Британи ЭСЯ-ны Түншлэлийн Хөтөлбөр

Санхүүжилт: 93, 834 фунд стерлинг буюу 145 сая 420 мянган төгрөг

Хөтөлбөрийн нэр: 3. ЯБУХ-ийн хүрээнд хэрэгжсэн Сургуулийн өмнөх боловсролыг дэмжих хөтөлбөр



1997 оны 12-р сар Төслийг хэрэгжүүлэх гэрээнд талууд гарын үсэг зурж байгаа нь

Хөтөлбөрийн зорилго: Ядуурлыг бууруулах хөтөлбөрийн хүрээнд СӨБ-ын салбарт дараах чиглэлийн төслүүдийг хэрэгжүүлсэн. Үүнд:

1. Цэцэрлэгүүдийг засварлах, гэр цэцэрлэг байгуулах
2. Цэцэрлэгийн үйлчлэх хүрээг өргөтгөх, үйл ажиллагааг сайжруулах
3. Иргэдийн үүсгэл санаачлагаар сайн дурын цэцэрлэг байгуулах, хүүхдийг асарч хүмүүжүүлэх сайн дурынхныг сургах
4. Бэлтгэл сургалт зохион байгуулах
5. СӨБ-ын багшлах боловсон хүчнийг давтан бэлтгэх

6. Сургалтын тоглоом наадгай, тоног төхөөрөмж үйлдвэрлэх, сургалтын хэрэглэгдэхүүн бэлтгэх

7. Цэцэрлэгийн туслах аж ахуйг дэмжих

8. Цэцэрлэгээс нэн ядуу өрхийн хүүхдийн хоол болон бусад зардлыг хариуцах чиглэлүүд болно.

Дээрх төслүүдийг хэрэгжүүлснээр:

- Төслийн хэрэгжилтийн явцад нийт 123 сумын 149 цэцэрлэг, нийслэлийн 5 дүүргийн 24 цэцэрлэг барилга/халаалтын системээ засварласан байна.


- Төсөлд хамрагдсан цэцэрлэгүүд нь өөрийн тойргийн нийт хүүхдийн 38,5 хувийг сургуулийн өмнөх боловсролд хамруулж, хамралтын үзүүлэлт үндэсний түвшинд 14,5 хувиар нэмэгдсэн байна.

- Иргэдийн үүсгэл санаачлагаар Улаанбаатар хот болон Дорноговь, Говьсүмбэр аймгуудад цэцэрлэгүүд байгуулагджээ.
- 1997 - 2000 онд төслийн хүрээнд 18976 хүүхэд бэлтгэл сургалтад хамрагджээ.
- Төслийн үр дүнд СӨБ-ын 2594 ажилтан 71 удаагийн богино хугацааны сургалтад хамрагдсан.
- 159 цэцэрлэг туслах аж ахуйтай болж, эдгээр аж ахуй нь 5731 толгой малтай, 54,2 га газартай болсон.
- Төслийн хүрээнд тоглоом наадгай, сургалтын хэрэглэгдэхүүн бэлтгэх чиглэлээр Орхон, Завхан, Төв аймаг болон Улаанбаатар хотод 6 төсөл хэрэгжсэн.
- 55457 хүүхдийн хоолны төлбөрийг төслөөс төлж сургуулийн өмнөх боловсролд шинээр хамруулсан.

Хамтран ажиллагч байгууллагууд:

- Ядуурлыг Бууруулах Үндэсний Хөтөлбөрийн Газар, Боловсрол Соёл Шинжлэх Ухааны Яам, хот, аймаг, сум, дүүргийн засаг даргын тамгын газар, бусад төрийн ба төрийн бус байгууллагууд, цэцэрлэгүүд.

Санхүүжилт: Голландын засгийн газраас 925,253 ам.доллар, ХИС (Англи) -аас 133,588 ам.доллар



Save the Children
10 жил
UK

Хөтөлбөрийн нэр: ХАРАА ХЯНАЛТГҮЙ ХҮҮХЭД

Хөтөлбөрийн зорилго: Халамжийн төв болон төвөөс гадуур амьдарч буй хараа хяналтгүй хүүхдүүдэд үзүүлэх халамж, хамгааллын үйлчилгээний чанарыг сайжруулах, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн ба төрийн бус байгууллагуудад нэвтрүүлэхүйц үйлчилгээний шинэ загварыг бий болгох

Хэрэгжсэн хугацаа: 1997-2004

Санхүүжүүлэгч:

Хүүхдийг ивээх сан (Англи), Хүүхдийг Ивээх сан (Япон), Канад сан, Монгол улс дахь Их Британий элчин сайдын яам, Монгол дахь Японы элчин сайдын яам, Бээжин дэх Австралийн элчин сайдын яам, Бээжин дэх Нидерландийн элчин сайдын яам, Японы Энх тайвны салхи, Дэлхийн банк, ЮНЕСКО, Хонгкокийн “Гэгээрлийн үр” сан, Сейнсбургийн Гэр бүлийн итгэл буяны сан, “Ди энд Жи” сан, Блэкле, Жонсон, Ингрид, Мани Казиро Шино нарын гэр бүлийн хандив гэх мэт

Санхүүжилт : 718 мянган фонд стерлинг буюу 1 тэрбум 113 сая төгрөг

Хамтран ажиллагч байгууллагууд:

Хүүхдийн төлөө үндэсний газар (хуучин нэрээр Хүүхдийн төлөө Үндэсний төв), Монголын Хүүхдийн эрхийн төв, Нийслэлийн Хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Дорнод, Сэлэнгэ, Төв, Дархан-Уул аймгийн Засаг даргын тамгын газар, Аймгийн Хүүхдийн төлөө төвүүд, Цагдаагийн Ерөнхий Газар болон Нийслэлийн цагдаагийн газар, Дорнод, Сэлэнгэ, Дархан-Уул аймгууд дахь Засаг даргын дэргэдэх Цагдаагийн хэлтсүүд, МУБИС-ийн Нийгмийн ажлын тэнхим



“Хараа хяналтгүй хүүхдүүдэд чиглэсэн бодлого, практик үйл ажиллагааг боловсронгуй болгох нь” үндэсний семинарын үеэр

Үйл ажиллагаа, үр дүн:

Монголын Засгийн газар ерээд оны дундуур гудамжны гэгдэх хараа хяналтгүй хүүхдүүдэд анхаарлаа хандуулахыг тус улсад үйл ажиллагаа явуулж буй олон улсын байгууллагуудад уриалсан. Энэ уриалгын дагуу ХИС (Англи) нь 1996-2000 онуудад Улаанбаатар хот, Дорнод, Дархан-Уул, Сэлэнгэ, Төв аймгуудад гэр орноосоо дайжсан, гудамжинд амьдарч буй хүүхдүүдэд зориулсан түр байрлуулах арван халамжийн төв, өдрийн үйлчилгээний хоёр төвийг Улаанбаатар хот ба Дорнод аймагт нээж ажиллуулсан.

Өнгөрсөн хугацаанд халамжийн төвүүдэд 1800 гаруй хүүхэд, өдрийн төвүүдэд 1300 гаруй хүүхэд чиглэсэн халамж, хамгаалал, нийгмийн ажлын болон бусад үйлчилгээг үзүүлэх, боловсрол олгох ба хөгжүүлэх зэрэг олон талт төслүүдийг хэрэгжүүлж ирсэн.

2001 оноос халамжийн төвүүдийг орон нутгийн засаг захиргааны мэдэлд шилжүүлэх, 2003 оноос хараа хяналтгүй хүүхдийн халамжийн төвийн үйл ажиллагааг өргөтгөн, хүүхдийг гэр бүлд нь буцаах, хараа хяналтгүй хүүхэд болохоос урьдчилан сэргийлэх, хүнд нөхцөлд амьдарч сурч байгаа илүү олон хүүхдэд хүрэх зорилгоор олон нийтэд түшиглэсэн Хүүхдийн хөгжил хамгааллын төвүүдийг бий болгох өөрчлөлтүүдийг хийж эхэллээ. Үүний үр дүнд өнөөдөр Улаанбаатар хотод халамжийн гурван төв, хараа хяналтгүй хүүхдэд чиглэсэн өдрийн

үйлчилгээний нэг төв, олон нийтэд түшиглэсэн нэг төв, Дорнод аймагт халамжийн нэг төв, олон нийтэд үйлчлэх гэр бүл мэдээллийн нэг төв тус тус үйл ажиллагаагаа явуулж байна. Харин ХИС-ийн тодорхой санхүүгийн дэмжлэг, орон нутгийн захиргааны шууд удирдлага дор Сэлэнгэ аймгийн Хүүхдийн төлөө төв болон Монголын Хүүхдийн эрхийн төв /МХЭТ/-ийн Дархан-Уул аймаг дахь салбар нь Сэлэнгэ, Дархан-Уул аймагт дахь халамжийн төвүүдийн үйл ажиллагааг эрхлэн явуулж байна.

Халамжийн, өдрийн болон олон нийтэд түшиглэсэн төвүүдийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, хүүхдэд ээлтэй халамж хамгааллын загварыг бий болгох зорилгоор төвүүдэд түшиглэсэн нийгмийн ажлын төрөл бүрийн үйлчилгээг бий болох, хүүхдийн хөгжил, оролцоо ба нийгэмших үйл явцыг дэмжсэн албан ба албан бус сургалтыг зохион байгуулах ба



Цирк төслийн хүүхдүүд: "Цирк", "Зуны зуслан" төслүүд нь Канад сангийн санхүүжилтээр хэрэгждэг.

сургалтанд хамруулах, нийгэмшүүлэх цирк, видео, театр зэрэг төслүүдийг хэрэгжүүлэх, төрөл бүрийн урлаг спортын дугуйланд хамруулах, зуны зусланг зохион байгуулах, төвүүдийн дэд бүтэц, тохижилтыг сайжруулах, боловсон хүчнийг бэлтгэх сургалтын тусгай хөтөлбөр боловсруулах, шаталсан сургалт зохион байгуулах зэрэг ажлуудыг хамтран ажиллагч байгууллагууд ба тус сангийн ажилтнуудын зүтгэлээр амжилттай хийж чадлаа.

Мөн хүнд нөхцөл дэх хүүхдүүдтэй ажиллах ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудтай хамтын ажиллагаагаа хөгжүүлэх, харилцан туршлага солилцох ажилд байнга анхаарч ажилласны үрээр бусад байгууллагуудын туршлагаас суралцахын зэрэгцээ хүүхдийн халамж хамгааллын үйлчилгээнд нийгмийн ажлын үйлчилгээг нэвтрүүлэх, Хүүхэд хамгаалал ба Оролцооны бодлогыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгох, боловсон хүчнийг бэлтгэх шаталсан сургалтыг зохион байгуулах, хараа хяналтгүй хүүхэдтэй ажиллах ажилтнуудад зориулсан гарын авлагыг ашиглах зэрэг Хүүхдийн ивээх сангийн туршлагыг бусад олон байгууллага сонирхож, үйл ажиллагаандаа нэвтрүүлсээр байна.

Хөтөлбөрийн нэр:**ХҮҮХЭД БА ХӨДӨЛМӨР**

Хөтөлбөрийн зорилго: Уг хөтөлбөр нь 1996 оноос эхэлсэн бөгөөд тухайн үед улам бүр өсөн нэмэгдэж байсан хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдийн өмнө тулгарч байгаа асуудлуудыг шийдвэрлэх, хүүхдийн хөдөлмөр эрхэлж буй нөхцөл, шалтгааны талаарх олон нийтийн



Хөдөлмөр эрхэлдэг хүүхдүүдийг Барилгын коллежид суралцуулах гэрээг тус сургууль дээр хийж байгаа нь

ойлголтыг нэмэгдүүлэх, хүнд хортой болон хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг багасгах, устгах, хүүхдүүдийг ажлаас нь хөндүүрүүлэхгүйгээр боловсрол эзэмших нөхцлийг баталгаажуулах, хүүхдэд мэргэжлийн чиг баримжаа олгоход чиглэгдсэн.

Хэрэгжсэн хугацаа: 1996 оноос хойш

Санхүүжүүлэгч байгууллага:

Их Британы Элчин Сайдын Яамны түншлэлийн хөтөлбөр, ХИС (Англи)

Санхүүжилт: 72,280 фунд стерлинг буюу 112 сая 15 мянган төгрөг

Хамтран ажиллагч байгууллагууд:

Хөдөлмөр эрхэлдэг хүүхдийн Мандах холбоо, Хүүхдийн Төлөө Үндэсний Газар, Дорнод, Увс, Баянхонгор, аймгуудын Хүүхдийн Төлөө Төв, Сүхбаатар, Баянзүрх дүүргийн албан бус боловсролын төвүүд, Монгол фермер сургууль, Монгол Солонгосын коллеж, Фермер эрхлэгчдийн эмэгтэйчүүдийн холбоо, "Тэгш мөр" ТББ, Үйлдвэрлэл урлалын дээд сургууль, Барилгын коллеж, Чингэлтэй дүүргийн өрхийн амьжиргааны чадавхийг нэмэгдүүлэх зөвлөл, "Чин хүслэн" бүлэг, Монголын эмэгтэйчүүдийн бизнесийн нэгдсэн төв, Дорнод аймаг дахь ЛЕОС-ийн салбар зөвлөл

Үйл ажиллагаа, үр дүн:

1996-1999 онуудад Английн Элчин сайдын яамны санхүүжилтээр хэрэгжсэн олон жижиг төслүүд нь ихэвчлэн хөдөлмөр эрхэлдэг хүүхдүүдэд мэргэжлийн чиг баримжаа олгох, тэдний орлогыг нэмэгдүүлэх, мэргэжлийн болон албан бус сургуульд хамруулахад чиглэгдэж байсан бөгөөд үүний үр шимийг хот хөдөөгийн олон хүүхдүүд хүртсэн. Анх Улаанбаатар хотод "Тэрэг", "Тоосго" төслүүдийг хэрэгжүүлэв. Энэ хугацаанд нийт 850 хүүхэд 10 гаруй мэргэжлээр курс сургуульд сурахын зэрэгцээ ихэнх нь албан бус болон бичиг үсэг тайлах сургалтуудад хамрагдсан ба мэргэжлийн сургууль төгсөөд шууд ажил эрхлэх нөхцөлийг хангахаар холбогдох үйлдвэр (Ноолуур, Ээрмэл) аж ахуйн газруудтай хамтран ажиллаж байсан. Мөн сурах бололцоогоор хангахын зэрэгцээ ерээд хүүхдэд зуны зусланд амрах тэтгэлэг олгосон. 1999 оноос хөдөлмөр эрхэлдэг хүүхдийн Мандах холбоо байгуулагдсанаар хүүхдүүдийн идэвх оролцоо нэмэгдэн одоо бие даасан байгууллага болоод байна. Тэдний оролцоотойгоор 2000 онд хөдөлмөр эрхэлдэг хүүхдүүдийн дунд хүүхдүүд хөдөлмөрийг юу гэж үздэг, хаана олноор хөдөлмөр эрхэлж байгаа болон тэдний хэрэгцээ байдлыг тодорхойлох судалгаа хийгдлээ.



"Ногоо" төсөл

ХИС хөдөлмөр эрхэлдэг хүүхдүүдээс НҮБ-ийн Хүүхдийн үндэсний тусгай чуулганд 1 хүүхэд, Монголд болсон Скаутын чуулганд 9 хүүхэд оролцуулсан. ХИС 2000 оноос хөдөлмөр эрхэлдэг хүүхдүүдэд зориулсан нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлж эхэлсэн ба жижиг төслүүдээр хөдөлмөр эрхэлдэг 700 хүүхэд болон тэдний эцэг эхчүүдэд зориулсан 20 гаруй төслийг хэрэгжүүлж амьдралын нөхцлөө сайжруулахад нь дэмжлэг үзүүлсэн байна.

Хөтөлбөрийн нэр: НИЙГМИЙН АЖЛЫН БОЛОВСРОЛ

Хөтөлбөрийн зорилго: Монголд нийгмийн ажлын боловсрол олгох, давтан бэлтгэх, нийгмийн ажилтныг дэмжих тогтолцоог хөгжүүлж, нийгмийн халамж, хамгааллын ялангуяа хүүхдийн халамж хамгааллын салбарт ажиллах мэргэжилтэй боловсон хүчнийг бий болгох, тэдний чадавхийг бэхжүүлэх

Хэрэгжсэн хугацаа: 1996-2001

Санхүүжүүлэгч байгууллага: Хүүхдийг ивээх сан (Англи), Монгол улсад суугаа Их Британий Элчин сайдын яам

Санхүүжилт: 334,000 фунд стерлинг буюу 517 сая 480 мянган төгрөг

Хамтран ажиллагч байгууллагууд:

Хүүхдийн төлөө үндэсний газар (хуучин нэрээр Хүүхдийн төлөө үндэсний төв), БСШУЯ, МУБИС (хуучин нэрээр УБИС)-ийн Нийгмийн ажлын тэнхим, Сурган сэтгэл судлалын тэнхим, Дорнод аймаг дахь Багшийн коллеж, Ховд аймаг дахь МУИС-ийн салбар их сургуулийн Сурган сэтгэл судлалын тэнхим, Монголын Нийгмийн ажилтны нийгэмлэг, Улсын Нийгмийн Халамжийн Газар, Монголын Хүүхдийн эрхийн төв, Монголын Нийгмийн ажилтны нийгэмлэг

Үйл ажиллагаа, үр дүн:

Тус хөтөлбөр нь Монголд нийгмийн ажлыг мэргэжил гэдэг утгаар анх танилцуулж, Нийгмийн ажлын боловсрол олгох тогтолцоог бүрдүүлэх, сургалтын хэрэгцээг тодорхойлох, багш нарыг бэлтгэх, сургалтын төлөвлөгөө хөтөлбөр боловсруулах, мэргэжлийн ном сурах бичгээр хангах ба эх хэл дээрх мэргэжлийн сурах бичиг бэлтгэн хэвлэх, МУБИС -ийн Нийгмийн ажлын тэнхим, Дорнод аймаг дахь Багшийн коллеж, МУИС-ийн Ховд аймаг дахь салбар их сургуулийн Нийгмийн ажлын сургалт судалгаа арга зүйн төвүүдийг байгуулж, тэнхим ба төвийн чадавхийг бэхжүүлэх, нийгмийн ажилтнуудын мэргэжлийн сүлжээг бий болгох, Монголын Нийгмийн ажилтны нийгэмлэгийг байгуулахад дэмжлэг үзүүлэх зэргээр Монголын нийгмийн ажлын үүсэл хөгжилд чухал үүрэг гүйцэтгэсэн.



“Нийгмийн ажил” хөтөлбөрийн үнэлгээний уулзалт 2002 он УБИС



Өнөөдөр МУБИС-ийн Нийгмийн ажлын тэнхим, МУИС-ийн Ховд аймаг дахь салбар их сургууль ба МУБИС-ийн харьяа Дорнод аймаг дахь Багшийн коллежийн Сурган сэтгэл судлалын тэнхимд нийт 13 багш ажиллаж, нийгмийн ажлын бакалаврын сургалтанд 360 оюутан, МУБИС-ийн нийгмийн ажлын магистрын хөтөлбөрт 18 оюутан хамрагдан суралцаж байна. Мөн нийгмийн халамж, хамгааллын салбарт ажиллаж буй 1000 гаруй ажилтнууд нийгмийн ажлын богино хугацааны сургалтанд хамрагдаж нийгмийн ажлын чиглэлээр мэргэжил мэдлэгээ дээшлүүлсэн билээ.

Хөтөлбөрийн нэр: СУРГУУЛИЙН НИЙГМИЙН АЖИЛТАН БЭЛТГЭХ БА СУРГУУЛЬ ЗАВСАРДАЛТААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ

Хөтөлбөрийн зорилго: Сургуулийн нийгмийн ажилтныг бэлтгэх, ерөнхий боловсролын сургуульд ажиллуулах, сургуульд сурагчдын сурах явцыг дэмжих тогтолцоог өргөтгөх замаар сургууль завсардалтаас урьдчилан сэргийлэх

Хэрэгжсэн хугацаа: 1996-2002

Санхүүжүүлэгч байгууллага: Хүүхдийг ивээх сан, Монгол дахь Их Британий Элчин сайдын яам

Санхүүжилт: 193,050 фунд стерлинг буюу 299 сая 182 мянган төгрөг

Хамтран ажиллагч байгууллагууд:

Монголын Хүүхдийн эрхийн төв, БСШУЯ, МУБИС (хуучин нэрээр УБИС)-ийн Нийгмийн ажлын тэнхим, Дорнод аймагт Багшийн коллеж, МУИС-ийн Ховд аймаг дахь салбар их сургуулийн Сурган сэтгэл судлалын тэнхим, Нийслэлийн Боловсролын газар, Дорнод, Баянхонгор, Баян-Өлгий, Ховд, Хөвсгөл, Дархан-Уул, Дундговь, Сэлэнгэ зэрэг аймгуудын Боловсрол соёлын газар, Аймгуудын Хүүхдийн төлөө төвүүд, Сургуулийн нийгмийн ажилтны нийгэмлэг

Үйл ажиллагаа, үр дүн:

Ерөнхий боловсролын сургуульд нийгмийн ажилтныг ажиллуулах замаар нийгмийн ажлын шинэ үйлчилгээг боловсролын тогтолцоонд бий болгох энэ хөтөлбөрийн анхны санаачлага 1996 онд УБ хотын 86, 57-р сургуулиудад туршилтын маягаар эхэлсэн. Улмаар энэхүү туршилтын төслийг Монголын Хүүхдийн эрхийн төвтэй хамтран долоон аймгийн сургуулиудад амжилттай хэрэгжүүлж, үндэсний хэмжээнд сургуулийн нийгмийн ажлын үйлчилгээг бий болгох суурийг тавьсан. Боловсролын үйлчилгээг хүртээмжтэй, чанартай болгоход сургуулийн нийгмийн ажилтан чухал үүрэгтэй гэж үзэн 2002 онд шинэчлэн баталсан Боловсролын багц хуулинд ерөнхий боловсролын сургуульд сургуулийн нийгмийн ажилтан ажиллана гэж шинээр тусгасан билээ.



Нийгмийн ажилтнуудын туршлага солилцох уулзалт
 Ховд, Баянхонгор аймгийн нийгмийн ажилтнууд Дорнод аймагт

Тус хөтөлбөрийн хүрээнд долоон аймгийн 219 сургуулийн багш, хүмүүжлийн эрхлэгч нар мэргэжлийн нийгмийн ажилтнаар бэлтгэгдэж, 100 гаруй сургуулийн нийгмийн ажилтан Хүүхдийн хамгаалал, Хүүхдийн эсрэг хүчирхийлэл, төсөл хөтөлбөр боловсруулах зэрэг чиглэлээр мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамрагдсан.

Мөн сургуулийн нийгмийн ажлын үйлчилгээний бодлого, зохицуулалтыг хангах БСШУЯ -ны Бага дунд тусгай боловсролын газрын дэргэдэх Сургуулийн нийгмийн нэгж энэ хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр байгуулагдаж,

нийгмийн ажлын үйлчилгээг дэлгэрүүлэх туршилтын төслүүд болон дотоод, гадаадад туршлага солилцох уулзалт, аялалууд зохион байгуулах, Сургуулийн нийгмийн ажлын практик сэтгүүлийг хэвлэн гаргах зэрэг үйл ажиллагаанууд тус хөтөлбөрийн хүрээнд дэмжигдсэн.

Хөтөлбөрийн нэр : ДОХ, БЗХӨ-өөс урьдчилан сэргийлэх

Хөтөлбөрийн Зорилго: ДОХ, БЗХӨ талаар өсвөр насны болоод хараа хяналтгүй хүүхдүүдийн мэдлэг мэдээллийг нэмэгдүүлэх

Хэрэгжсэн хугацаа: 1997-2001

Санхүүжүүлэгч байгууллага: Хүүхдийг Ивээх Сан (Англи), Их Британий Элчин Сайдын Яамны түншлэлийн хөтөлбөр

Санхүүжилт: 24,690 фонд стерлинг буюу 39 сая 257 мянган төгрөг

Хамтран ажиллагч байгууллагууд:

ЭМНХЯ (тэр үеийн нэрээр), Эрүүл Мэндийн удирдлага, мэдээлэл, боловсролын төв, ДОХ-той тэмцэх үндэсний сан, Хил Хязгааргүй эмч нар, УБДС-ийн Нийгмийн ажлын тэнхим, "Үерхэл" сонин, "Амар мэнд" сэтгүүлийн редакц, хот хөдөөгийн ЕБС-ийн нийгмийн ажилтнууд



Зөвлөх Петер Блэклей хүүхдүүдийн хамт

Үйл ажиллагаа, үр дүн:

ХИС-аас ДОХ, БЗХӨ-ий талаар хүүхдэд зориулан хялбаршуулсан сургалтын хөтөлбөр, гарын авлагыг тэдний оролцоо, санал бодлыг үндэслэн гаргасан. Сургалтыг явуулах сургагч багш болон үе тэнгийн сургагч нарыг бэлтгэж эхэлсэн.



Үе тэнгийн сургагч нар

Төслийн хэрэгжилтийн хугацаанд 10 аймаг, Улаанбаатар хотын нийт 34 сургуулийн нийгмийн ажилтан, 2100 хүүхэд, 175 орчим багш "Амьдрах ухааны сургалт"-нд хамрагдан сургагч багшаар, 50 хүүхдийг үе тэнгийн сургагчаар бэлтгэсэн бөгөөд сургалтанд хараа хяналтгүй 800 хүүхэд, сургуулийн 3000 сурагч, 150 багш, 200 эцэг эхчүүд хамрагдсан байна.

ХИС-аас үе тэнгийн сургагч нарыг зуны зуслангуудад ажиллуулж Улаанбаатар хотын 12 зусланд нийт 1880 хүүхдийг үе тэнгийн сургагчаар бэлтгэн, Сэлэнгэ аймгийн 586 хүүхдийг сургалтанд хамруулсан байна.

Сургалтын үр дүнд хүүхдийн дунд ДОХ, БЗХӨ-ий талаар болоод хүмүүсийн харилцаа, үерхэл нөхөрлөл, хайр дурлал, хүний болон өсвөр насны хүүхдийн бие махбодийн онцлог, өөрчлөлтүүд, эрүүл ахуйн ерөнхий мэдлэг нэмэгдэн, хүүхэд хүүхэддээ сургалт явуулдаг арга нь хүүхдүүдийн идэвхийг нэмэгдүүлэн, хүүхдүүд санаа бодлоо чөлөөтэй илэрхийлж сурахад нөлөөлсөн. Багш хүүхдүүд, эцэг эх хүүхдүүд, хүүхэд хүүхэдтэйгээ өөрсдийн өмнө тулгарсан асуудлыг ярилцан бие биеэсээ зөвөлгөө авах, харилцан туслах дотно харьцаа бий болсон.

Хөтөлбөрийн нэр: ХҮҮХДИЙН ЭСРЭГ ХҮЧИРХИЙЛЭЛ БА ХАМГААЛАЛ

Хөтөлбөрийн зорилго: Хүүхдийг хүчирхийллээс хамгаалах, урьдчилан сэргийлэх тогтолцоог бэхжүүлэх, энэ чиглэлээр ажиллаж буй төрийн ба төрийн бус байгууллагуудын чадавхийг бэхжүүлэх, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх

Хэрэгжсэн хугацаа: 2000 оноос өнөөг хүртэл

Санхүүжилт: 68,140 фунд стерлинг буюу 105 сая 596 мянган төгрөг

Хамтран ажиллагч байгууллагууд:

Төрийн бус байгууллага: Хүчирхийллийн эсрэг үндэсний төв (ХЭҮТ), Баянхонгор, Дорнод аймаг дахь ХЭҮТ-ийн салбарууд, Хүүхдийг хүчирхийллээс хамгаалах, урьдчилан сэргийлэх алба, Монголын Хүүхдийн эрхийн төв, Хүүхдийн төлөө ажилладаг төрийн бус байгууллагын эвсэл, Глоб Интернейшнл төрийн бус байгууллага, Хүүхэд залуучуудын хөгжлийн төв, Архидалт мансуурлын эсрэг ассоциацийн Улаанбаатар дахь төв болон Дорнод дахь салбарууд, Гэрэлт Ирээдүй төв, Тахир дутуу эмэгтэйчүүдийн холбоо

Төрийн байгууллага: Хүүхдийн төлөө үндэсний газар, Нийслэлийн Хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Цагдаагийн Ерөнхий Газрын Олон нийттэй харилцах хэлтэс, Баянхонгор, Дорнод аймгийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн хэлтэс

Үйл ажиллагаа, үр дүн:

Энэ хөтөлбөрийн хүрээнд Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн Хүүхэд хамгааллын нэгж (ХХН) байгуулах, тус нэгжийн чадавхийг бэхжүүлэх, хүүхдийн эсрэг хүчирхийллийн чиглэлээр



Хүүхдийн эсрэг хүчирхийллийн чиглэлээр хүүхдийн клубын удирдагч нарын бэлтгэх сургалт ХЭҮТ 2002 он

судалгаа хийх, олон нийтийн мэдлэгийг нэмэгдүүлэх, хүчирхийллийн талаарх хүмүүсийн хэвшсэн сөрөг хандлагын тухай үзэсгэлэнг төв суурин болон орон нутагт гаргах, хэвлэл мэдээллийн аян зохион байгуулах, гарын авлага бэлтгэх зэрэг ТББ-уудын санал санаачлагуудыг дэмжсэн.

Өнгөрсөн хугацаанд ХЭҮТ ийн дэргэдэх ХХН-ээр хүчирхийлэл дарамтанд өртсөн 390 хүүхдүүд, тэдний эцэг эх үйлчлүүлж, нийгмийн ажил, сэтгэл засал болон хууль эрх зүйн үйлчилгээнүүдээс хүртсэн.

Мөн ХИС-ийн Олон нийтэд үйлчлэх төвийн ажилтнууд ХХН-тэй хамтран хохирогч хүүхдэд

үзүүлэх нийгмийн ажлын үйлчилгээг хорооны нийгмийн ажилтан, цагдаа, эмч болон хуульчдаас бүрдсэн хамтарсан багаар хүргэх ажлыг туршиж байна. ХЭҮТ-тэй хамтран Жендерийн талаарх хэвшмэл хандлага, хүчирхийллээс хамгаалах тухай үзэсгэлэнг УБ хотод Баянхонгор зэрэг аймгуудад, ХЭҮТ ба Глоб интернейшнл байгууллагуудтай хамтран хүүхдийн эсрэг хүчирхийллийг зогсоох, олон нийтийн мэдлэгийг нэмэгдүүлэх чиглэлээр хэвлэл мэдээллийн аяныг Улаанбаатар, Дорнод, Баянхонгор аймгуудад тус тус зохион байгуулсан. Мөн хэвлэл мэдээллийн аяныг зохион байгуулах, цаашид хамтран ажиллах олон мэргэжилтнүүдээс бүрдсэн хоёр баг орон нутагт бэлтгэгдсэн.

Хөтөлбөрийн хүрээнд архины хор хөнөөлөөс сэргийлэх сургалт сурталчилгааг Хүүхэд залуучуудын хөгжлийн төв, Архидалт мансуурлын эсрэг ассоциацийн Улаанбаатар дахь төв болон Дорнод дахь салбартай хамтран зохион байгуулж хот, аймаг, сумын олон мянган хүүхэд, залуучууд, эцэг эхэд хүргэж чадсан.

Хөтөлбөр хэрэгжүүлэх хугацаанд хүүхдийн төлөө ажилладаг 62 ТББ-ийг нэгтгэсэн эвсэл, төслийн санхүүжилтээр өөрийн сонинтой болж хамтын ажиллагаагаа өргөжүүлэх, чадавхаа бэхжүүлэхийн зэрэгцээ Хүүхдийн эрхийг хамгаалах хуульд өөрчлөлт оруулах ажилд идэвхтэй оролцсон.

Хүүхдийн төлөө үндэсний газрын 2004-2010 хүртэлх стратеги боловсруулах ажлыг дэмжиж, тус байгууллагын чиг хандлага, ажиллагааны чиглэлийг тодорхойлоход бусад санхүүжүүлэгч байгууллагуудтай хамтран дэмжлэг үзүүлсэн.

ЦЕГ-ийн Олон нийттэй харилцах хэлтэс, Баянхонгор, Дорнод аймгийн Цагдаагийн хэлтэстэй хамтран хүнд нөхцөл дэх хүүхдийг бичиг баримттай болгох, хохирогч хүүхдэд үзүүлэх үйлчилгээг хүүхдэд ээлтэй болгох чиглэлээр хамтран амжилттай ажиллаж байна.



Save the Children
70 years

Хөтөлбөрийн нэр: БАЙГАЛИЙН ГАМШГИЙН ҮР ДАГАВРЫГ БУУРУУЛАХ

Хөтөлбөрийн зорилго: Гамшгийн үр дагаврыг бууруулах хөтөлбөр нь гамшгийн үед хүүхдийн үндсэн эрхүүдийг сэргээх, хүүхдийг амьдралын наад захын хэрэгцээ болох орон байр, хоол хүнсээр хангах, эцэг эх, асран хамгаалагчидтай нь уулзуулах, шаардлагатай бол гамшгийн голомтоос нүүлгэн шилжүүлэх, төрөл бүрийн хүчирхийлэл, дарамтаас урьдчилан сэргийлэх, хамгаалах ажлуудыг нэн тэргүүнд зохион байгуулах зорилготой билээ.

Үйл ажиллагаа, үр дүн:

1. Баянхонгор 2000 оны зуд

1999—2000 оны өвөл манай улсад сүүлийн хэдэн арван жилд үзэгдээгүй хүйтэн, цас ихтэй өвөл болж нийтдээ 13 аймгийг хамарсан зуд болсон. 2000 оны хавар Хүүхдийг Ивээх Сан



Баянхонгор аймагт зудын байдалд үнэлгээ хийж илүү хүнд байдалд байгаа 6 сумд гамшгийн үр дагаврыг бууруулах хөтөлбөр хэрэгжүүлэхээр шийдсэн.

Хөтөлбөр нь үндсэн гурван чиглэлээр хэрэгжсэн юм.

- Малаа их хэмжээгээр буюу бүрэн алдсан 5-с доош насны олон хүүхэдтэй тэтгэмжээс өөр орлогогүй 420 өрхөд гурил, цагаан будааг олгосон.

- 6 сумын 1-5 насны 3000 хүүхэд, 2000 жирэмсэн эхчүүдийг витаминжуулах ажлыг зохион байгуулж, олон төрөлт витамин сумын эмнэлгээр дамжуулан тараасан.

- Зудын үеэр сургууль, цэцэрлэг, эмнэлгийн эдийн засгийн байдал хүндэрсэн ба энэ байдлаас гарахад нь туслах зорилгоор 6 сумын 18 сургууль, цэцэрлэг, эмнэлгийг хүнсний ногоо тарих боломжоор хангасан.

Санхүүжилт: 121,300 фунд стерлинг буюу 187 сая 934 мянган төгрөг

Санхүүжүүлэгч байгууллага: Европын холбооны Хүмүүнлэгийн байгууллага

2. Ховд 2001 оны зуд

2000-2001 оны өвөл Монгол улсын ихэнх нутгийг хамарсан зуд болсон. ХИС Ховд аймгийн Булган, Үенч, Алтай сумдуудад гамшгийн үр дагаврыг бууруулах 2 шаттай хөтөлбөрийг 2001, 2002 онуудад хэрэгжүүлсэн байна.

Хөтөлбөр нь дараах зорилттой хэрэгжсэн.

- Төл болон эх малын хорогдлыг багасгах зорилгоор 200-с доош толгой малтай 856 ядуу өрхөд өвс, малын тэжээл тараасан.

- Мөн олон хүүхэдтэй нийт 699 өрхөд 9.24 тн гурил, 2.64 тн цагаан будаа бүхий хүнсний туслалцаа үзүүлсэн.

- 3 сумын сургуулийн дотуур байрны хүүхдүүдэд 660 ор дэрний хэрэглэл, цэцэрлэг, эмнэлэг, сургуульд түлш, хүнсний туслалцаа үзүүлсэн.

Санхүүжилт: 212,911 фунд стерлинг буюу 330 сая төгрөг

Санхүүжүүлэгч: “Брук” эмнэлэг, Их Британы Олон улсын хөгжлийн газар

3. Дорнод 2001 оны шүлхий

2001 онд Дорнодод малын шүлхий өвчин гарч гаднаас нийлүүлдэг хүнсний хангамж багасан, хүнсний зах, дэлгүүр хаагдсанаас хүнсний өргөн хэрэгцээний бараа болон бүтээгдэхүүний үнэ өсч, зах дээр зогсон өдрийн хоолоо залгуулж амьдардаг хараа хяналтгүй хүүхдүүд болоод ядуу өрх айлуудын амьдралд хүнд цохилт болсон юм.

Төслөөр дараах зорилтуудыг хэрэгжүүлсэн.

- Хэрлэн сумын хараа хяналтгүй 40 хүүхдийг түр орогнох байраар хангах
- Сарын 15, 000 төгрөгөөс бага орлоготой 300 гаруй өрх, хараа хяналтгүй хүүхдүүд болон сургуулийн дотуур байранд амьдардаг 223 хүүхдүүдэд хүнсний туслалцаа үзүүлэх
- 950 өрхийг халдваргүйжүүлэлтийн энгийн материалуудаар хангах
- Мардай суман дах ядуу өрхийн 32 хүүхдэд хүнс, эм бэлмэл олгох
- Малын шүлхий өвчин түүнээс урьдчилан сэргийлэх талаар олон нийтийн мэдлэг мэдээллийг нэмэгдүүлэх ажлуудыг зохион байгуулсан

Санхүүжилт: 6641 фунд стерлинг буюу 10 сая 290 мянган төгрөг

Санхүүжүүлэгч байгууллага: Их Британы Олон улсын хөгжлийн газар

4. Дундговь 2003 оны зуд

ХИС Дундговь аймгийн тамгийн газрын хүсэлтээр тус аймгийн Эрдэнэдалай, Адаацаг сумдуудаар үнэлгээ хийж, зудын гамшигийг бууруулах гамшигт нэрвэгдсэн ядуу өрхийн хүүхдүүд рүү чиглэсэн төслийг хэрэгжүүлсэн.

Төсөл нь дараах зорилтуудыг хэрэгжүүлсэн.

- 2 сумын нийт 3 буюу түүнээс дээш хүүхэдтэй 370 өрхөд гурил, цагаан будаа, ургамлын тос олгох,
- 50-120 мал бүхий 530 өрхөд малын тэжээл, шар будаа олгох,
- Эрдэнэдалай сумын дотуур байранд 74 ор дэрний хэрэглэлээр ханган дотуур байранд хүүхэд авах нөхцөлийг бүрдүүлэх
- Адаацаг сумын эмнэлэг, сургууль, цэцэрлэгт тус бүр 20-30 тн түлш олгох



Дундговь аймаг Адаацаг сум, 2003 он

Санхүүжилт: 20,000 фунд стерлинг буюу 31 сая төгрөг

Санхүүжүүлэгч байгууллага: ХИС (Англи)

10 ЖИЛИЙН САНХҮҮГИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭ

	Хөтөлбөр/төсөл	СЖ94/95	СЖ95/96	СЖ96/97	СЖ97/98	СЖ98/99	Дүн
1	Хөтөлбөр	100,000.00	56,012.00	108,007.00	0.00	0.00	264,019
2	Боловсрол				102,581.00	67,500.00	170,081
3	ЯБҮХ		55,343.00	47,374.00	72,697.00	25,216.11	200,630
4	Хараа хяналтгүй хүүхэд				32,325.00	78,511.00	110,836
5	Хараа хяналтгүй хүүхэд Барилга						0
6	Хүүхэд ба хөдөлмөр						0
7	Нийгмийн халамж, нийгмийн бодлого				56,803.00	109,736.89	166,540
8	Нийгмийн ажлын тэнхим, АЗТ				47,336.00	38,000.00	85,336
9	Сургууль завсардалтаас урьдчилан сэргийлэх					9,166.00	9,166
10	Хүүхдийн эсрэг хүчирхийлэл, хүүхэд хамгаалал						0
11	ДОХ/БЭХӨ					10,000.00	10,000
12	Гамшгийн үр дагаврыг бууруулах						0
13	Хүнсний аюулгүй байдал					8,199.00	8,199
14	Захиргаа		57,450.00	64,901.00	87,471.00	118,072.00	327,894
15	Дорнод дахь салбар						0
	Нийт	100,000.00	168,805.00	220,282.00	399,213.00	464,401.00	1,352,701
		71,000,000	121,539,600	213,673,540	518,976,900	696,601,500	1,521,791,540

(фунт стерлинг)

	Хөтөлбөр/төсөл	СЖ99/00	СЖ00/01	СЖ01/02	СЖ02/03	СЖ03/04	Нийт дүн
1	Хөтөлбөр	0.00	0.00	0.00	0.00	0.00	264,019
2	Боловсрол	72,807.00	99,239.41	107,652.00	121,543.00	198,964.00	770,286
3	ЯБҮХ	22,693.00				0.00	223,323
4	Хараа хяналтгүй хүүхэд	67,626.00	96,771.00	128,503.00	128,166.00	131,826.00	663,728
5	Хараа хяналтгүй хүүхэд Барилга		0.00	35,795.00	18,558.00	0.00	54,353
6	Хүүхэд ба хөдөлмөр		31,272.00	23,414.00	12,293.00	5,301.00	72,280
7	Нийгмийн халамж, нийгмийн бодлого	63,490.00	31,879.00	6,915.00	35,465.00	29,627.00	333,916
8	Нийгмийн ажлын тэнхим, АЗТ	38,000.00	18,330.00	7,483.00		2,851.00	152,000
9	Сургууль завсардалтаас урьдчилан сэргийлэх		19,646.00	12,241.00		0.00	41,053
10	Хүүхдийн эсрэг хүчирхийлэл, хүүхэд хамгаалал		0.00	15,144.00	23,605.00	29,389.00	68,138
11	ДОХ/БЭХӨ		5,000.00	9,686.00		0.00	24,686
12	Гамшгийн үр дагаврыг бууруулах	57,647.00	216,135.59	67,038.00	517.00	19,483.00	360,821
13	Хүнсний аюулгүй байдал		9,404.00	596.00		0.00	18,199
14	Захиргаа	136,103.00	135,274.00	135,809.00	174,276.00	182,581.00	1,091,937
15	Дорнод дахь салбар		0.00	13,809.00	22,389.00	13,000.00	49,198
	Нийт	458,366.00	662,951.00	564,085.00	536,812.00	613,022.00	4,187,937
		733,385,600	1,093,869,150	902,536,000	912,580,400	1,226,044,000	6,490,206,690

Тайлбар: СЖ - санхүүгийн жил

Д.Тунгалаг
ХИС (Англи)-ийн
Санхүүгийн Ажилтан

Санхүүжүүлэгч, хандивлагч байгууллагууд:

1. Их Британий Элчин Сайдын Яам
2. Их Британий Олон Улсын Хөгжлийн Газар
3. Японы Засгийн Газар
4. Бээжин дэх Нидерландын ЭСЯ
5. Бээжин дэх Австралийн ЭСЯ
6. Дэлхийн Банк
7. Азийн Хөгжлийн Банк
8. НҮБ-ын Хүүхдийн Сан
9. ЮНЕСКО
10. Канад Сан
11. Японы Хүүхдийг Ивээх Сан
12. Канадын “Ди энд Жи” сан
13. “Энх тайвны салхи” Японы ТББ
14. Европын Холбооны Хүмүүнлэгийн Байгууллага (ЕСНО)
15. Европын Холбооны ТАСИС хөтөлбөр
16. Ашден Траст (Сейнсбюрийн Гэр бүлийн итгэл буяны сан)
17. Окинава ТТБ
18. “Гэгээрлийн Үр” Сан, Гонг Конг
19. Брүкийн Эмнэлэг (ВНА)
20. Жерсийн Олон Улсын Тусламжийн Хороо
21. Гүрнсийн Олон Улсын Тусламжийн Хороо

Хандивлагч хувь хүмүүс:

1. Мани Казиро Шино нарын гэр бүлийн хандив (Mani Kazuo Shino) Japan
2. Малколм энд Надине Блэкли,
3. Жонсоны гэр бүл (JANSEN)
4. А1 сан
5. Крис Жонстон
6. Ингрид Жакобссон
7. Роберт Жон Фишер
8. Дюрамын гэр бүл
9. Кентийн Гүн Эдвард
10. Үлрих Күэн
11. Кяоко Танами
12. Майкл энд Марилин Ди
13. Элин Хектор
14. Дэвид Воодбайн
15. Кенвин Смит
16. Срефен Э. Нөрпер
17. Хатагтай Гэйл Свот
18. Степ Инн клуб
19. Матвей Врингстоны Буяны Сан
20. Шведийн Хүүхдийг Ивээх Сан
21. Илен Хектор



Хаяг:

Монгол Улс
Улаанбаатар -11
Төв шуудан, хайрцаг 1023
Утас: 329365, 329371
Факс: 976-11-329361
И-мэйл: monscf@magicnet.mn
Веб: www.savethechildrenmongolia.mn